



И-Х/2022

Тархаасан: 2022 оны 12 дугаар сарын 14



## Улсын нийт гадаад өр 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 873.4 сая ам.доллаар буурчээ

Улсын нийт гадаад өр 2022 оны эхний 9 сард 32.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 873.4 (2.6%) сая ам.доллаар, өмнөх улирлаас 814.0 (2.5%) сая ам.доллаар буурсан байна.

Нийт гадаад өрийн 12.3 (37.8%) тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг, 8.9 (27.3%) тэрбум ам.доллар нь бусад салбарынх, 7.6 (23.5%) тэрбум ам.доллар нь Засгийн газрынх, 2.3 (7.1%) тэрбум ам.доллар нь Төв банкных, 1.4 (4.2%) тэрбум ам.доллар нь Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх байна.

Улсын нийт гадаад өр 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс буурахад Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх 300.3 (18.0%) сая ам.доллар, Засгийн газрын гадаад өр 829.3 (9.8%) сая ам.доллаар буурсан нь нөлөөлсөн байна. Харин Шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг 133.5 (1.1%) сая ам.доллар, бусад салбарынх 79.3 (0.9%) сая ам.доллар, Төв банкных 43.4 (1.9%) сая ам.доллаар тус тус өсжээ.

### ХҮСНЭГТ 1. УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, сая ам.доллар

Үзүүлэлт	2020 И-Х	2021 И-Х	2022* И-Х	<u>2022* И-Х</u> 2021 И-Х
	сая ам.доллар			хувь
<b>Нийт гадаад өр</b>	31 192.5	33 319.8	32 446.4	97.4
Засгийн газар <sup>1</sup> (Зах зээлийн үнэлгээгээр, эзэмшигчээр)	8 052.2	8 449.1	7 619.8	90.2
Төв банк	2 154.5	2 272.6	2 316.0	101.9
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1 769.5	1 672.1	1 371.8	82.0
Бусад салбарууд	8 016.4	8 783.3	8 862.6	100.9
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	11 199.9	12 142.7	12 276.2	101.1

Эх үүсвэр: Монголбанк

<sup>1</sup> Зах зээлийн үнэлгээ, аккрузал суурьд үндэслэсэн дүн

Засгийн газрын нийт өр 2022 оны эхний 9 сард 30.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (11.0%) их наяд төгрөг, өмнөх улирлаас 1.6 (5.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын дотоод өр 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 297.0 (28.4%) тэрбум төгрөгөөр, өрийн баталгаа 185.1 (20.4%) тэрбум төгрөгөөр, барих-шилжүүлэх төрлийн концесс 120.6 (19.1%) тэрбум төгрөгөөр тус тус буурч, гадаад өр 3.6 (14.6%) их наяд төгрөгөөр өсжээ.

ХҮСНЭГТ 2. ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг


Үзүүлэлтүүд	2020 I-Х	2021 I-Х	2022* I-Х	$\frac{2022^* \text{ I-Х}}{2021 \text{ I-Х}}$
<b>Засгийн газрын нийт өр</b>	26 267.4	27 151.0	30 137.2	111.0
Засгийн газрын дотоод өр	1 317.6	1 046.1	749.1	71.6
Үнэт цаас	1 317.6	1 046.1	749.1	71.6
Засгийн газрын гадаад өр <sup>2</sup>	23 039.4	24 566.8	28 155.7	114.6
Үнэт цаас	8 276.8	8 174.6	9 565.3	117.0
Зээл	14 762.6	16 392.2	18 590.4	113.4
Засгийн газрын өрийн баталгаа	1 050.2	906.6	721.5	79.6
Барих-Шилжүүлэх төрлийн концесс	860.2	631.5	510.9	80.9

Эх үүсвэр: Сангийн яам

<sup>2</sup>Нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн дүн

Засгийн газрын нийт өрийн 28.2 (93.4%) их наяд төгрөг нь гадаад өр, 749.1 (2.5%) тэрбум төгрөг нь дотоод өр, 721.5 (2.4%) тэрбум төгрөг нь Засгийн газрын өрийн баталгаа, 510.9 (1.7%) тэрбум төгрөг нь барих-шилжүүлэх төрлийн концесс тус тус эзэлж байна.

ЗУРАГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Сангийн Яам

Засгийн газрын нийт өрөөс 2022 оны эхний 9 сард үндсэн төлбөрт 670.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 581.5 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Үндсэн төлбөрийн төлөлт өмнөх оны мөн үеэс 396.3 (37.2%) тэрбум төгрөгөөр, хүүгийн төлбөр өмнөх оны мөн үеэс 134.2 (18.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

**Улсын нийт гадаад өр:** Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэдээс Монгол Улсад бүртгэлгүй, эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг ойлгоно. Үүнд гадаад зээл, өрийн бичиг, харилцах хадгаламж, худалдааны зээл болон урьдчилгаа болон бусад өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийг хамруулна.

**Засгийн газрын дотоод өр:** Өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг ойлгоно.

**Засгийн газрын гадаад өр:** Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг ойлгоно.

Үүнд гадаад зээл, өрийн бичиг, дотоод үнэт цааснаас эдийн засгийн харьяат бус этгээдийн эзэмшиж буй дүн болон бусад өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийг хамруулна.

**Засгийн газрын өр:** Засгийн газрын дотоод өр, засгийн газрын гадаад өрийн нийлбэр байна.

**Концесс:** Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Барих-шилжүүлэх төрлөөр байгуулсан концессын гэрээний хүрээнд гарсан ашиглалтыг үндэслэн бүртгэсэн дүнг хэлнэ. Концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ юм.



**Эх үүсвэр:**

Сангийн яам;  
Монголбанк;

**Ангилал, код:**

Эдийн засгийн секторын ангилал

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2023 оны 3 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тэгшжаргал  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын статистикч Э.Цэнд-Аюуш  
Утас : (976-51)-326414



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212